



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Инженер, технологийн дээд боловсрол төслийн 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** СНАГ-2025/002/НА-СТА-ТХН

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Улаанбаатар хот 2025 он</p>	<p>Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор : Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: <a href="mailto:naranchimegts@audit.gov.mn">naranchimegts@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Д.Энхдалай Утас: 260512 Цахим хаяг: <a href="mailto:enkhdalaid@audit.gov.mn">enkhdalaid@audit.gov.mn</a></p> <p>Аудитор: Я.Марал-Эрдэнэ Утас: 261628 Цахим хаяг: <a href="mailto:maral-erdeneya@audit.gov.mn">maral-erdeneya@audit.gov.mn</a></p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ди Эй Би Жи Аудит ХХК-ийн захирал Н.Дэлгэрмаа Утас: 976-91910954 Цахим хаяг: <a href="mailto:dabq.audit@gmail.com">dabq.audit@gmail.com</a></p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 07/675  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ИНЖЕНЕР ТЕХНОЛОГИЙН ДЭЭД  
БОЛОВСРОЛ ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ  
Д.НАМСРАЙ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Инженер, технологийн дээд боловсрол төслийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Монгол Улсын Засгийн Газар, Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага хооронд 2014 оны 3 дугаар сарын 12-ны өдөр байгуулсан MON-P11 тоот хөнгөлөлттэй зээлийн хэлэлцээрийн дагуу Монгол Улсад өндөр мэдлэг, ур чадвар бүхий инженер, технологийн мэргэжилтэн бэлтгэж, инженерийн боловсролын өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, багшлах боловсон хүчний нөөцийг бэхжүүлж, сургалтын орчныг шинэчлэн, чанарыг сайжруулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх төслийг 2025 оны 3 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Төсөл хэрэгжих хугацаанд дутуу зарцуулагдсан 1.2 тэрбум иен буюу 28,718,983.6 мянган төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг бүрэн ашиглах шийдвэр гарч талууд 2023 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр шинэчилсэн "Санамж бичиг"-т гарын үсэг зурж баталгаажуулан, төслийн хугацааг 2027 оны 6 дугаар сар хүртэл сунгасан байна.

Төслийн үлдэгдэл санхүүжилтийг Монгол улсын их сургууль, Шинжлэх ухаан технологийн их сургууль, Хөдөө аж ахуйн их сургуулиудад шаардлагатай сургалт

судалгааны лаборатори болон үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж нийлүүлэхэд зарцуулахаар төлөвлөсөн байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн ректорын 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/387 тоот тушаалаар Инженер технологийн дээд боловсрол төслийн хүрээнд Коосэн, Бакалаврын хамтарсан хөтөлбөрөөр Шинжлэх ухаан технологийн их сургууль болон Японы их сургуулиудад амжилттай суралцаж төгсөн Монгол улсад мэргэжлийн дагуу 5 жил ажилласан төгсөгчдийн гэрээний үүргийн биелэлтийг дүгнэх 9 хүний бүрэлдэхүүнтэй Ажлын хэсэг байгуулсан байна.

Ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн Боловсролын яамны Боловсролын зээлийн сангийн ажлын албаны даргын 2025 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн А/07 дугаар тушаалаар төслийн санхүүжилтээр Япон улсад инженер, технологийн чиглэлээр коосэн, магистр, докторын хөтөлбөрт 2014-2019 оны хооронд суралцаж, эх орондоо ирээд 5 жил ажилласан 23 иргэний хүсэлтийг хүлээн авч шалгаж, 22 иргэний 2,723,363.8 мянган төгрөгийн гэрээний үүргийг дуусгавар болгон зээлээс чөлөөлсөн шийдвэр гарсан байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Төслийн нийт хугацаа 2014-2024 онд 5 бүрэлдэхүүний хүрээнд 11 бүлэг үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл тайлант оны эцэст 94.6 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *В. Наранчимэг* Ц.НАРАНЧИМЭГ



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>69,628,413,408.76</b>	<b>70,713,621,154.75</b>
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>3,418,731,709.18</b>	<b>395,810,426.82</b>
31200	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>3,418,731,709.18</b>	<b>395,810,426.82</b>
31220	<b>Гадаад валют</b>	<b>3,418,731,709.18</b>	<b>395,810,426.82</b>
31222	Монгол банкин дахь харилцах	2,359,564,134.40	40,090,020.51
31223	Арилжааны банкин дахь харилцах	1,059,167,574.78	355,720,406.31
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	<b>1,353,449,713.57</b>
33510	Байгууллагаас авах авлага	-	1,353,449,713.57
34	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>66,209,286,899.58</b>	<b>68,963,966,214.36</b>
34600	Урьдчилж гарсан зардал	66,209,286,899.58	68,963,966,214.36
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>394,800.00</b>	<b>394,800.00</b>
354	Хангамжийн материал	394,800.00	394,800.00
35420	Аж ахуйн материал	90,000.00	90,000.00
35470	Бусад хангамжийн материал	304,800.00	304,800.00
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>812,436.14</b>	-
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>812,436.14</b>	-
392	<b>Биет хөрөнгө</b>	<b>812,436.14</b>	-
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	25,513,476.34	25,513,476.34
39206	Хуримтлагдсан элэгдэл	(24,972,040.31)	(25,513,476.34)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	15,492,990.95	15,492,990.95
39208	Хуримтлагдсан элэгдэл	(15,221,990.84)	(15,492,990.95)
393	<b>Биет бус хөрөнгө</b>	-	-
39301	Програм хангамж	770,000.00	770,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(770,000.00)	(770,000.00)
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>69,629,225,844.90</b>	<b>70,713,587,154.75</b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	<b>183,900,311.97</b>	<b>34,000.00</b>
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>183,900,311.97</b>	<b>34,000.00</b>
41300	<b>Өглөг</b>	<b>183,900,311.97</b>	<b>34,000.00</b>
41310	Ажиллагсадтай холбоотой өглөг	-	34,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	183,900,311.97	-
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>69,445,325,532.93</b>	<b>70,713,587,154.75</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>69,445,325,532.93</b>	<b>70,713,587,154.75</b>
51200	Хуримтлагдсан үр дүн	69,445,325,532.93	70,713,587,154.75
51210	Өмнөх үеийн үр дүн	67,662,441,515.05	69,445,325,532.93
51220	Тайлант үеийн үр дүн	1,782,884,017.88	1,268,261,621.82
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>69,629,225,844.90</b>	<b>70,713,621,154.75</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>9,592,261,100.60</b>	<b>6,119,882,614.79</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>9,129,066,800.60</b>	<b>5,569,838,414.79</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>9,129,066,800.60</b>	<b>5,569,838,414.79</b>
120044	Гадаад эх үүсвэрээс санхүүжих	9,129,066,800.60	5,569,838,414.79
13	<b>ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>463,194,300.00</b>	<b>550,044,200.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	463,194,300.00	550,044,200.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>7,525,144,611.92</b>	<b>4,582,672,125.97</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,830,149,554.08</b>	<b>3,663,795,592.67</b>
210	<b>Бараа, ажил үйлчилгээний зардал</b>	<b>2,822,757,237.50</b>	<b>3,642,422,174.75</b>
210101	Үндсэн цалин	325,804,522.00	373,990,509.50
210201	Нийгмийн даатгалын шимтгэл	40,725,564.42	46,748,812.50
2103	<b>Байр ашиглалтын тогтмол зардал</b>	<b>3,150,000.00</b>	<b>5,400,000.00</b>
210304	Байрны түрээсийн зардал	3,150,000.00	5,400,000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>11,138,640.00</b>	<b>13,442,911.08</b>
210401	Бичиг хэргийн зардал	3,224,000.00	3,925,909.08
210402	Тээвэр, шатахууны зардал	6,200,000.00	6,400,000.00
210404	Ном хэвлэлийн зардал	400,000.00	791,696.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,314,640.00	2,325,306.00
2107	<b>Томилолт зочны зардал</b>	<b>51,248,676.00</b>	<b>57,875,179.00</b>
210701	Гадаад томилолт	51,149,676.00	57,543,758.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	99,000.00	331,421.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал</b>	<b>2,381,917,559.36</b>	<b>3,144,152,326.53</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал	2,381,917,559.36	3,144,152,326.53
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>8,772,275.72</b>	<b>812,436.14</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,299,900.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	3,472,375.72	812,436.14
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>7,392,316.58</b>	<b>21,373,417.92</b>
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>7,392,316.58</b>	<b>21,373,417.92</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,392,316.58	21,373,417.92
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>4,694,995,057.84</b>	<b>918,876,533.30</b>
222001	Тоног төхөөрөмж	4,694,995,057.84	918,876,533.30
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН</b>	<b>2,067,116,488.68</b>	<b>1,537,210,488.82</b>
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО</b>	<b>1,186,843,497.55</b>	<b>692,880,974.38</b>
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	1,186,843,497.55	692,880,974.38
5	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ</b>	<b>1,471,075,968.35</b>	<b>961,829,841.38</b>
225004	Гадаад валютын ханшийн зөрүүгийн гарз	1,471,075,968.35	961,829,841.38
6	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН</b>	<b>1,782,884,017.88</b>	<b>1,268,261,621.82</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>5,002,138,362.00</b>	<b>2,733,499,750.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>4,538,944,062.00</b>	<b>2,183,455,550.00</b>
120	<b>Төсөвт байгууллагын өөрийн орлого</b>	<b>4,538,944,062.00</b>	<b>2,183,455,550.00</b>
120044	Гадаад эх үүсвэрээс санхүүжих	4,538,944,062.00	2,183,455,550.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>463,194,300.00</b>	<b>550,044,200.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	463,194,300.00	550,044,200.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>7,440,555,810.87</b>	<b>5,504,707,836.55</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>7,440,555,810.87</b>	<b>5,504,707,836.55</b>
210	<b>Бараа, ажил үйлчилгээний зардал</b>	<b>7,433,163,494.29</b>	<b>5,483,334,418.63</b>
210101	Үндсэн цалин	323,120,704.00	373,956,509.50
210201	Нийгмийн даатгалын шимтгэл	40,415,000.42	46,748,812.50
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>3,150,000.00</b>	<b>5,400,000.00</b>
210304	Байрны түрээсийн зардал	3,150,000.00	5,400,000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>9,938,640.00</b>	<b>13,442,911.08</b>
210401	Бичиг хэргийн зардал	3,224,000.00	3,925,909.08
210402	Тээвэр, шатахууны зардал	5,000,000.00	6,400,000.00
210404	Ном хэвлэлийн зардал	400,000.00	791,696.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,314,640.00	2,325,306.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>51,248,676.00</b>	<b>57,875,179.00</b>
210701	Гадаад албан томилолт	51,149,676.00	57,543,758.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах зардал	99,000.00	331,421.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>6,997,306,755.87</b>	<b>4,985,911,006.55</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал	6,997,306,755.87	4,985,911,006.55
2109	<b>Бараа, үйлчилгээний бусад зардал</b>	<b>7,983,718.00</b>	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,983,718.00	-
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>7,392,316.58</b>	<b>21,373,417.92</b>
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>7,392,316.58</b>	<b>21,373,417.92</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,392,316.58	21,373,417.92
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(2,438,417,448.87)</b>	<b>(2,771,208,086.55)</b>
4	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
5	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	1,180,896,424.12	692,880,974.38
225004	Гадаад валютын ханшийн зөрүүгийн гарз	1,420,556,103.67	944,594,170.19
7	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(239,659,679.55)</b>	<b>(251,713,195.81)</b>
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(2,678,077,128.42)</b>	<b>(3,022,921,282.36)</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,096,808,837.60	3,418,731,709.18
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,418,731,709.18	395,810,426.82

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	<b>67,662,441,515.05</b>	<b>67,662,441,515.05</b>
Тайлант үеийн үр дүн	-	1,782,884,017.88	1,782,884,017.88
<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	<b>69,445,325,532.93</b>	<b>69,445,325,532.93</b>
Тайлант үеийн үр дүн	-	1,268,261,621.82	1,268,261,621.82
<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	<b>70,713,587,154.75</b>	<b>70,713,587,154.75</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>9,805,044,200.00</b>	<b>8,869,717,283.42</b>	<b>935,326,916.58</b>	<b>90.5</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>6,750,044,200.00</b>	<b>6,412,214,818.65</b>	<b>337,829,381.35</b>	<b>95.0</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>6,750,044,200.00</b>	<b>6,412,214,818.65</b>	<b>337,829,381.35</b>	<b>95.0</b>
210101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	375,052,500.00	373,956,509.50	1,095,990.50	99.7
210201	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,881,700.00	46,748,812.50	132,887.50	99.7
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>5,400,000.00</b>	<b>5,400,000.00</b>	-	<b>100.0</b>
210303	Байрны түрээс	5,400,000.00	5,400,000.00	-	100.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>17,450,000.00</b>	<b>13,442,911.08</b>	<b>4,007,088.92</b>	<b>77.0</b>
210401	Бичиг хэрэг	4,500,000.00	3,925,909.08	574,090.92	87.2
210402	Тээвэр, шатахуун	6,400,000.00	6,400,000.00	-	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	450,000.00	-	450,000.0	0.0
210404	Ном, хэвлэл	3,600,000.00	791,696.00	2,808,304.00	22.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,500,000.00	2,325,306.00	174,694.0	93.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>66,860,000.00</b>	<b>57,875,179.00</b>	<b>8,984,821.00</b>	<b>86.6</b>
210701	Гадаад албан томилолт	58,000,000.00	57,543,758.00	456,242.00	99.2
210702	Дотоод албан томилолт	8,500,000.00	-	8,500,000.00	-
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах зардал	360,000.00	331,421.00	28,579.00	92.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>6,238,400,000.00</b>	<b>5,914,791,406.57</b>	<b>323,608,593.43</b>	<b>94.8</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,238,400,000.00	5,914,791,406.57	323,608,593.43	98.9
<b>222</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>3,055,000,000.0</b>	<b>2,457,502,464.77</b>	<b>597,497,535.23</b>	<b>80.4</b>
222001	Тоног төхөөрөмж	3,055,000,000.0	2,457,502,464.77	597,497,535.23	80.4
<b>1</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>9,805,044,200.00</b>	<b>6,098,509,196.87</b>	<b>3,706,535,003.13</b>	<b>62.2</b>
<b>120</b>	<b>Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас</b>	<b>9,255,000,000.00</b>	<b>5,569,838,414.79</b>	<b>3,685,161,585.21</b>	<b>60.2</b>
120044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	9,255,000,000.00	5,569,838,414.79	3,685,161,585.21	60.2
<b>13</b>	<b>Улсын төсвөөс санхүүжих</b>	<b>550,044,200.00</b>	<b>528,670,782.08</b>	<b>21,373,417.92</b>	<b>96.1</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	550,044,200.00	528,670,782.08	21,373,417.92	96.1
3	Тохируулгын дүн		(251,713,195.81)		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		3,418,731,709.18		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		395,810,426.82		
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>				
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>		<b>100.0</b>
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>12</b>	<b>7</b>	5	<b>58.3</b>
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	11	6	5	54.5

### 3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нийт 3,386,382.8 мянган төгрөгийн 2 алдаа илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийсэн.

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Дд	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
								Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Зөвлөх үйлчилгээний төлбөр 928,880.4 мянган төгрөг, тоног төхөөрөмжийн төлбөр 2,457,502.4 мянган төгрөг, нийт 3,386,382.8 мянган төгрөгийн шууд төлбөрийг Мөнгөн гүйлгээний тайланд Гадаад эх үүсвэрийн санхүүжилтээр ангилан бүртгэсэн.	1	3,386,382.8			1	3,386,382.8	1	3,386,382.8		
2	Төсвийн тухай хуулийн 54.5.4-д заасны дагуу хөтөлбөр арга хэмжээний төсвийн гүйцэтгэл, үр дүнг бүрэлдэхүүн тус бүрээр өссөн дүнгээр төлөвлөгөөтэй зэрэгцүүлэн мөнгөн дүн, хувиар илэрхийлэн тайлагнаагүй байна.	1	-	1	-			1	-		
<b>Дүн</b>		<b>2</b>	<b>3,386,382.8</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>3,386,382.8</b>	<b>2</b>	<b>3,386,382.8</b>	<b>-</b>	<b>-</b>

3.2 Аудитаар илэрсэн нийт 29,924.3 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Дд	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Урьдчилж гарсан зардал дансны 29,924.2 мянган төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна	1	29,924.2	-	-	1	29,924.2	-	-	-	-	-	-
<b>Дүн</b>		<b>1</b>	<b>29,924.2</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>29,924.2</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

3.3 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээллийг тогтоосон хугацаанд иж бүрэн байршуулаагүй 9,805,044.2 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж хүргүүлэв

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих нийт 171 мэдээллээс 163 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 5 мэдээллийн хугацаа болоогүй, хугацаа хоцроон байршуулсан 3 мэдээ байгаа нь 98.2 хувийн гүйцэтгэлтэй байна.	1	9,805,044.2			1	9,805,044.2
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>9,805,044.2</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>9,805,044.2</b>